

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/10/НА-СТА-ТШЗ

|                                                                              |         |                                                                                                                                                                                                                                                                              |
|------------------------------------------------------------------------------|---------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Алтай хот | 2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: М.Атарцэцэг<br>Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn |
|                                                                              |         |                                                                                                                                                                                                                                                                              |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.07 № 15

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хантайшир уулын аймгийн 100 жилийн ойн хүрээнд хүүхдийн баяр наадмын нээлтийн арга хэмжээ, урлагийн тоглолт, үндэсний бөх, сурын харваа, шагайн харваа, шагайн морин уралдаан зэрэг тэмцээн уралдааныг зохион байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 4,683.5 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй 9,600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 19,365.6 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 4 зорилтын хүрээнд 25 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 22 арга хэмжээг 100.0 хувь, 1 арга хэмжээг 90.0 хувь, 2 арга хэмжээг 70.0 хувь буюу нийт дүнгээр 97.2 хувиар үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /Мян.Төгрөгөөр/**

|                                                | Үзүүлэлт                                          | 2022.12.31          | 2023.12.31          |
|------------------------------------------------|---------------------------------------------------|---------------------|---------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                     |                     |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 66,247.77           | 68,646.88           |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 2,996,174.56        | 2,896,702.59        |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>3,062,422.33</b> | <b>2,965,349.47</b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | 25,094.76           | 0.00                |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 3,037,327.57        | 2,965,349.47        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>3,062,422.33</b> | <b>2,965,349.47</b> |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 4,046,369.30        | 1,007,334.90        |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 795,835.03          | 966,048.28          |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>3,250,534.27</b> | <b>41,286.63</b>    |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | -                   | -                   |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>3,250,534.27</b> | <b>41,286.63</b>    |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   | 3,030,107.08        | (68,940.77)         |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 7,227.72            | 3,037,327.57        |
|                                                | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт  | -                   | -                   |
|                                                | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                    | -                   | -                   |
|                                                | Тайлант оны үр дүн                                | 3,030,099.85        | (71,978.10)         |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>3,030,107.08</b> | <b>(68,940.77)</b>  |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                     |                     |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 817,343.03          | 970,731.77          |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 795,835.03          | 966,048.28          |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | 21,508.00           | 4,683.49            |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | (21,508.00)         | (4,683.49)          |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | -                   | -                   |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | -                   | -                   |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -                   | -                   |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -                   | -                   |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   |                     |                     |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>651,318.95</b>   | <b>851,078.50</b>   |
|                                                | Урсгал зардал                                     | 651,318.95          | 851,078.50          |
|                                                | Хөрөнгийн зардал                                  | -                   | -                   |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>651,318.95</b>   | <b>851,078.50</b>   |
|                                                | Улсын төсвөөс санхүүжих                           | 651,318.95          | 851,078.50          |
|                                                | Орон нутгийн төсвөөс санхүүжих                    | -                   | -                   |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос      |                     |                     |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 41,945.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийг 41,791.5 мянган төгрөгөөр илүү тооцсон, санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 153.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 6,212.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6,212.0 мянган төгрөгийн 8 зөрчил<sup>2</sup> илэрч 564.0 мянган төлбөрийн акт, 5,648.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 4 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Ажилчдад 200.0 мянган төгрөгийн гарт олгох цалин, 200.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг дутуу тооцож олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Тухайн цалин, нэмэгдэл тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг нэмж тусгана", Байгууллагын даргын 2023 оны Б/26 дугаар тушаал"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу тооцож олгосон цалинг ажилчдад буцаан олгох төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын даргын тушаалаар олгосон түлшний хөнгөлөлтөөс ажилчдад 164.0 мянган төгрөгийг дутуу олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Байгууллагын даргын 2023 оны Б/43 дугаар тушаал"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу тооцож олгосон түлшний хөнгөлөлтийг ажилчдад буцаан олгох төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж урсгал засварын төсвөөс 546.0 мянган төгрөгийн номын тавиур бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" Урсгал засвар: Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

материал, сэлбэг, засвар үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Ажилчдад олгосон 3,062.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлтөөс нийгмийн даатгал татвар суутгаагүй, цалингийн урьдчилгаа 2,400.0 мянган төгрөгийг олгохдоо давхардуулан нийгмийн даатгал, татвар суутгасан нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19.1-т "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна: 19.1.3-т "Ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын шимтгэл, татварын суутгалыг хуулийн дагуу хийж байх албан шаардлага хүргүүлсэн

3. Байгууллагын цайны газрыг 11, 12 сард түрээсийн гэрээ байгуулахгүйгээр төлбөргүй түрээслүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээслэгч байгууллагатай гэрээ байгуулж түрээсийн төлбөрийг төлүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Шатахууны зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Шатахууны тооцооны хуудсыг зориулалт тус бүрээр бус арга хэмжээгээр нь бүхэл дүнгээр хөтөлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулалтын жолоочийн тооцооны хуудсыг дүрэм журмын дагуу дэлгэрэнгүй, үнэн зөв хөтлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/  
/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр         | Алдааны утга                                                                          | Нийт алдаа |          | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |          | Үүнээс:    |          |              |     | Зөвлөмж |     |
|---------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|------------|----------|-----------------------------------|-----|--------------------------|----------|------------|----------|--------------|-----|---------|-----|
|                                             |                                                                                       |            |          |                                   |     |                          |          | Залруулсан |          | Залруулаагүй |     |         |     |
|                                             |                                                                                       | Тоо        | Дүн      | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн      | тоо        | Дүн      | тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| 1                                           | 2                                                                                     | 3          | 4        | 5                                 | 6   | 7                        | 8        | 9          | 10       | 11           | 12  | 13      | 14  |
| Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар | Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийг 41,791.5 мянган төгрөгөөр илүү тооцсон         | 1          | 41,791.5 | -                                 | -   | 1                        | 41,791.5 | 1          | 41,791.5 | -            | -   | -       | -   |
|                                             | Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 153.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1          | 153.7    | -                                 | -   | 1                        | 153.7    | 1          | 153.7    | -            | -   | -       | -   |
| Дүн                                         |                                                                                       | 2          | 41,945.2 | -                                 | -   | 2                        | 41,945.2 | 2          | 41,945.2 |              |     | -       | -   |

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга                                                                                            | Нийт алдаа, зөрчлийн дүн |       | Үүнээс:       |       |                 |       |         |    |                                         |    |
|-------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-------|---------------|-------|-----------------|-------|---------|----|-----------------------------------------|----|
|                                     |                                                                                                                      |                          |       | Төлбөрийн акт |       | Албан шаардлага |       | Зөвлөмж |    | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн |    |
|                                     |                                                                                                                      | Тоо                      | Дүн   |               |       |                 |       |         |    |                                         |    |
| 1                                   | 2                                                                                                                    | 3                        | 4     | 5             | 6     | 7               | 8     | 9       | 10 | 11                                      | 12 |
|                                     | Ажилчдад 200.0 мянган төгрөгийн гарт олгох цалин, 200.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг дутуу тооцож олгосон | 1                        | 400.0 | 1             | 400.0 |                 |       | -       | -  | -                                       | -  |
|                                     | Байгууллагын даргын тушаалаар олгосон түлшний хөнгөлөлтөөс ажилчдад 164.0 мянган төгрөгийг дутуу олгосон             | 1                        | 164.0 | 1             | 164.0 |                 |       |         |    |                                         |    |
|                                     | Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж урсгал засварын төсвөөс 546.0 төгрөгийн номын тавиур бэлтгэсэн                  | 1                        | 546.0 |               |       | 1               | 546.0 |         |    |                                         |    |

**Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

|                                             |                                                                                                                                                                                                            |          |                |          |              |          |                |          |          |          |          |
|---------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|----------------|----------|--------------|----------|----------------|----------|----------|----------|----------|
| Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар | Ажилчдад олгосон 3,062.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлтөөс нийгмийн даатгал татвар суутгаагүй, цалингийн урьдчилгаа 2,400.0 мянган төгрөгийг олгохдоо давхардуулан нийгмийн даатгал, татвар суутгасан. | 1        | 5,102.0        |          |              | 1        | 5,102.00       |          |          |          |          |
|                                             | Шатахууны тооцооны хуудсыг зориулалт тус бүрээр бус арга хэмжээгээр нь бүхэл дүнгээр хөтөлсөн                                                                                                              | 1        | -              |          |              |          |                | 1        |          |          |          |
|                                             | Байгууллагын цайны газрыг 11,12 сард түрээсийн гэрээ байгуулахгүйгээр төлбөргүй түрээслүүлсэн.                                                                                                             | 1        | -              |          |              | 1        |                |          |          |          |          |
| <b>Нийт</b>                                 |                                                                                                                                                                                                            | <b>6</b> | <b>6,212.0</b> | <b>2</b> | <b>564.0</b> | <b>3</b> | <b>5,648.0</b> | <b>1</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр         | Алдаа, зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | Нийт алдаа, зөрчлийн дүн |          | Үүнээс:       |          |                 |          |          |          |
|---------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|----------|---------------|----------|-----------------|----------|----------|----------|
|                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Тоо                      | Дүн      | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |          | Зөвлөмж  |          |
|                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                          |          | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн      | Тоо      | Дүн      |
| 1                                           | 2                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 3                        | 4        | 5             | 6        | 7               | 8        | 9        | 10       |
| Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар | Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 4,122.7 мянган төгрөгийн 13 , төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 540.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 593,444.4 мянган төгрөгийн 29, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 76 шийдвэрийг хугацаа хоцорч мэдээлсэн. | 1                        | -        | -             | -        | -               | -        | 1        | -        |
|                                             | Хүүхдийн хөгжил, хамгааллын зардлаас 12,139.0 мянган төгрөг, гэр бүлийн хөгжил хамгааллын зардлаас 512.0 мянган төгрөг, залуучууд болон оюутнуудын зардлаас 2,212.0 мянган төгрөг, нийт 14,863.0 мянган төгрөгийг хоол цай, усанд зарцуулсан байна.                                                                                                                                                                       | 1                        | -        |               |          | 1               |          |          |          |
| <b>дүн</b>                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | <b>2</b>                 | <b>-</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>-</b> | <b>1</b> | <b>-</b> |